# ДОРНОГОВЬ АЙМГИЙН
# ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 04 өдөр Дугаар А/565 Сайншанд сум

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 "а", 29.2 дахь заалт, Засгийн газрын 2020 оны "Газар тариалангийн тогтвортой хөгжлийг дэмжих зарим арга хэмжээний тухай" 138 дугаар тогтоол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны "Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аяныг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай" А-118 дугаар тушаал, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны "Хөтөлбөр батлах тухай" 35 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Монгол малчин" аймгийн дэд хөтөлбөрийн төлөвлөгөөг нэгдүгээр, "Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян"-ы төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг орон нутагт үр дүнтэй зохион байгуулж, хагас, бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар /Ж.Наранболд/, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /А.Амгаланзаяа/-т үүрэг болгосугай.

**МОНГОЛ МАЛЧИН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ**
**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**
**/2020-2024/**

2020 оны 08 дугаар сарын 04-ний өдөр — Сайншанд хот

| № | Бодлогын зорилт | Хэрэгжүлэх арга хэмжээ | Хугацаа | Хөрөнгийн эх үүсвэр, төсөв /сая төгрөг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хамтрах хэрэгжүүлэх |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| *Зорилт 1: Малчдыг мэдлэгжүүлэх, мэдээллээр хангах аян өрнүүлж, тэдгээрийн мэдлэг, туршлага, чадавхыг сайжруулах, хөгжүүлэх, малчдын залуу халааг бэлтгэх;* | | | | | | | | |
| 1.1.1 | 1.1. Малчдыг мэдлэгжүүлэх, мэдээллээр хангах аяныг аймгийн хэмжээнд өрнүүлж, малчдын мал маллах ухаан, аж ахуй эрхлэх арга барил, туршлагыг дэлгэрүүлсэн тэргүүний сумыг 2 жилд нэг удаа шалгаруулах; | Малчдыг туршлага судлах арга хэмжээ хамруулах */Малын чанар- Дэлгэрэх, Бэлчээр ашиглалт- Улаанбадрах, Хөвсгөл, Малчдын бүлэг-Эрдэнэ, Малчдын хоршоо – Алтаншираэ, бусад/* | 2020-2024 | ОНТ 5,0 | Арга хэмжээний тоо, хамрагдсан малчдын тоо | Арга хэмжээний тоо-1, хамрагдсан малчдын тоо-18 | Сургалт 4, Малчин- 104 | АЗДТГ, ХХААГ, СЗДТГ, ТББ |
| 1.1.2 | | Аймгийн хэмжээнд малчдыг мэдлэгжүүлэх, мэдээллээр хангах аян өрнүүлж “Өрхийн мэдээллийн сан”-тай болгох | 2020-2024 | ОНТ 7,0 | Мэдээллийн сантай болсон малчин өрхийн тоо | - | 4231 | АЗДТГ, ХХААГ, МЭГ, ЭМГ, НДГ, Сумдын ЗДТГ, ТББ |
| 1.1.3 | | Залуу малчдад мал маллах, малын чанар, түүхий эдийн бэлтгэлийн талаар 2-5 хоногийн танхимын | 2020-2024 | ОНТ 8,0 | *Зохион байгуулсан сургалтын тоо- 56,* | *Зохион байгуулсан сургал* | Сургалт - 56, | АЗДТГ, ХХААГ, МЭГ, ЭМГ, НДГ, |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | сургалтыг сум бүрд зохион байгуулах | | | *Сургалтад хамрагдсан залуу малчдын тоо - 560* | *тын тоо- 3, хамрагдсан малчин* | Малчин -560 | СЗДТГ, ТББ |
| 1.1.4 | | Аймгийн нийт малчин өрхийн нэгдсэн судалгаа, мэдээллийн программ нэвтрүүлэх, хөтлөх | 2022-2023 | ОНТ 5,0 | Программ нэвтрүүлсэн сумын тоо | - | 14 | АЗДТГ, ХХААГ, СЗДТГ, ХХ |
| 1.1.5 | | Тэргүүн туршлага судлах, нэвтрүүлсэн шилдэг сумын шалгаруулах | 2021, 2024 | ОНТ 2,0 | Сумын тоо | - | 2 | АЗДТГ, ХХААГ, МЭГ, ЭМГ, НДГ, Сумдын ЗДТГ, ТББ |
| 1.2.1 | 1.2. Малчинд мэргэжилийн үнэмлэх, малчин өрхийн баталгааны тэмдэг олгох, хэрэглэхтэй холбогдсон хууль, журам, шаардлага, ач холбогдлыг таниулах; | Мэргэжлийн байгууллагаас олгосон "Малчин мэргэжлийн үнэмлэх"-ийг орон нутгийн малчдад шуурхай хүргэж нийт малчдыг хамруулах | 2023-2024 | - | Арга хэмжээний тоо | - | 2 | АЗДТГ, ХХААГ, БСУГ, СЗДТГ |
| 1.2.2 | | Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхой болгох | 2020-2024 | - | Тухайн жилд гарал үүслийн гэрчилгээ олголтын хувь | 80 | 100 | ХХААГ, МЭГ, СЗДТГ |
| 1.3.1 | 1.3. Мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшлийг ашиглан малчдад хэрэгцээт мэдээллийг шуурхай хүргэх, энэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг ашиглахад сурган | "Масс мессеж" үйлчилгээ хүргэх | 2020-2024 | ОНТ 20,0 | Малчдын хамрагдалтын хувь | 84,6 | 100 | АЗДТГ, ХХААГ |
| 1.3.2 | | Үүрэн холбооны газруудтай хамтран мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшлийг ашиглан сургалт, мэдээллийг малчдад хүргэх | 2020-2024 | - | Арга хэмжээний тоо | - | Арга хэмжээ-28 | ХХААГ, СЗДТГ, ХХ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хүртээмжийг нэмэгдүүлж орон зайн хамаарлыг бууруулах; | | | | | | | |
| 1.4.1 | 1.4. Гэрээт болон туслах малчдад чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах | Гэрээт болон туслах малчдын судалгаа хийж, сан үүсгэн хөтлөх | 2020-2024 | - | Судалгааны ажлын гүйцэтгэлийн хувь | - | 100 | ХХААГ, СЗДТГ |
| 1.4.2 | | Мал аж ахуй, орон нутгийн онцлогт тохируулан туслах малчдын хөдөлмөрийг үнэлэх, харилцааг зохицуулах журам батлан мөрдүүлэх | 2022 | - | Журам боловсруулалтын хувь | - | 100 | АЗДТГ, ХХААГ, СЗДТГ, ТББ |
| 1.4.3. | | Гэрээт болон туслах малчидтай уулзалт, арга хэмжээг бүсчлэн зохион байгуулах | 2021, 2024 | ОНТ 2,5 | Арга хэмжээний тоо | - | 8 | АЗДТГ, ХХААГ, МЭГ, ЭМГ, НДГ, Сумдын ЗДТГ, ТББ |
| *Зорилт 2: Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоонд чанарын үнэлэмж бий болгох зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх;* | | | | | | | | |
| 2.1.1 | 2.1. Сумдын мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг төвлөрүүлэн бэлтгэх, нийлүүлэх малчдын хувь нийлүүлсэн оролцоотой хоршоо, нөхөрлөлийг дэмжих; | Хөдөө аж ахуйн сургагч багш бэлтгэх, давтан сургаж чадавхижуулах | 2021-2024 | ОНТ 3,0 | Сургагч багштай сумын тоо | - | 14 | АЗДТГ, ХХААГ, СЗДТГ, ТББ |
| 2.1.2 | | Сургагч багш нараар дамжуулан малчдын хувь нийлүүлсэн оролцоотой хоршоо, нөхөрлийг мэргэжил арга зүйгээр хангах | 2020-2024 | - | Жилд 2-оос доошгүй удаа | - | 28 | ХХААГ, СЗДТГ |
| 2.1.3 | | Хоршоо, нөхөрлөл байгуулахад хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх | 2020-2024 | СХС ЖДҮДС, бусад | Байгуулагдсан нөхөрлөл, хоршооны тоо | - | 14 | АЗДТГ, ХХААГ, СЗДТГ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2.1 | 2.2. Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийг малчин, мал бүхий өрх тус бүрээр тодорхойлох, чанарыг үнэлэх, баталгаажуулах | Мал эмнэлгийн нэгдсэн систем нэвтрүүлэн, хөтлөх | 2020-2024 | - | Систем нэвтрүүлэлтийн хувь | - | 100 | МЭГ, СЗДТГ |
| 2.2.2 | | Сумдад мал эмнэлгийн гэрчилгээ олгох тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх | 2020-2021 | ОНТ 15,0 | Тоног төхөөрөмж нэвтрүүлсэн сумын тоо | - | 14 | АЗДТГ, МЭГ, СЗДТГ, ХХ |
| 2.2.3 | | Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний үнэ, чанарын талаар тусгай нэвтрүүлэг бэлтгэн олон нийтэд хүргэх | 2021-2024 | ОНТ 1,1 | Бэлтгэсэн нэвтрүүлгийн тоо */улиралд-1/* | - | 12 | АЗДТГ, ХХААГ, СЗДТГ, ХХ |
| 2.3.1 | 2.3. Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанар, гарал үүслийг баталгаажуулан малчдын гар дээрээс хэрэглэгчдэд шууд хүргэх арга хэмжээ авах; | Малчдын үзэсгэлэн худалдаа зохион байгуулах | 2021-2024 | ОНТ 6,0 | Тухайн жилд зохион байгуулсан үзэсгэлэн худалдааны тоо | - | 4 | АЗДТГ, ХХААГ, СХЗХ, МХГ, МЭГ, СЗДТГ |
| 2.3.2 | | Малчдын үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг худалдан борлуулах, сурталчилах нэгдсэн цэг байгуулах | 2021-2024 | УТ, ОНТ, бусад | Цэгийн тоо | - | 1 | АЗДТГ, ХХААГ, СХЗХ, МХГ, МЭГ, СЗДТГ, ХХ |
| *Зорилт 3: Малчин өрхийн үйлдвэрлэлийн бүтээмж, нөөц ашиглалтыг нэмэгдүүлэх замаар орлого, ашгийг өсгөн орон нутагтаа ая тухтай ажиллах, амьдрахад бодлогын дэмжлэг үзүүлэх;* | | | | | | | | |
| 3.1.1 | 3.1. Малчин өрх, малчдын үйлдвэрлэлийн бүтээмж, нөөц ашиглалтыг | Малчин өрх, малчдын үйлдвэрлэлийн бүтээмж, нөөц ашиглалтыг нэмэгдүүлэх хүчин зүйлсийг тодорхойлох судалгаа хийх | 2021 | УТ, ОНТ, бусад | Судалгааны ажлын гүйцэтгэлийн хувь | - | 100 | АЗДТГ, ХХААГ, СЗДТГ, ХХ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.2 | нэмэгдүүлэх хүчин зүйлсийг тодорхойлж, тэдгээрийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх | Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн боловсруулах тоног, төхөөрөмжийг нэвтрүүлэх төсөл хэрэгжүүлэх | 2022-2023 | УТ, ОНТ, ХХ, бусад | Төсөл хэрэгжүүлсэн сумын тоо | - | 2-оос доошгүй | АЗДТГ, ХХААГ, СЗДТГ, ХХ |
| 3.2.1 | 3.2. Малчдыг эрүүл мэндийн үзлэг, оншлогоонд жил бүр хамруулах. | Төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч, мэргэжилтнүүдийн багийн түвшинд ажиллуулж малчдыг үзлэг, оношилгоо, шинжилгээ, эмчилгээнд хамруулах | 2021-2024 | ОНТ 150,0 | Үзлэг, оншилгоо, шинжилгээ, эмчилгээнд малчдын хамрагдалтын хувь | 15 | 50 | АЗДТГ, ХХААГ, СЗДТГ, ХХ |
| 3.2.2 | | Сумдын Эрүүл мэндийн төвүүдэд Мобайл технологи */тоног төхөөрөмж/* нэвтрүүлж малчдын орон зайн хамаарлыг бууруулах | 2020-2024 | УТ, ОНТ-70,0 | Мобайл технологи нэвтрүүлсэн сумын тоо | 4 | 14 | АЗДТГ, ХХААГ, ЭМГ, СЗДТГ, бусад |
| 3.3.1 | 3.3. Малчин өрхийн гишүүдийг насан туршийн боловсролын төв, нэгжүүдээр дамжуулан боловсрол, мэдлэг, чадвар олгох, бага насны хүүхдүүдэд эцэг, эх, асран хамгаалагчдын оролцоотойгоор СӨБ эзэмшүүлэх; | Насан туршийн боловсролын төв, нэгжийн сургалтад малчдыг хамруулах | 2020-2024 | ОНТ 1,0 | Сургалтад хамрагдсан малчдын тоо | - | | АЗДТГ, ХХААГ, БСУГ, СЗДТГ |
| 3.3.2 | | Малчин залуу эцэг, эхчүүдэд хүүхэд хүмүүжүүлэх, төлөвшүүлэх, сургах арга барил эзэмшүүлэх арга хэмжээ зохион байгуулах | 2021-2024 | ОНТ 5,0 | Арга хэмжээ зохион байгуулсан сумын тоо | - | 14 | АЗДТГ, ХХААГ, БСУГ, СЗДТГ |
| 3.3.3 | | Малчин өрхийн 2-5 насны хүүхдэд чиглэсэн "Шинэ үсний багш" хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 2021-2024 | ОНТ 5,0 | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | - | 100 | АЗДТГ, ХХААГ, БСУГ, СЗДТГ |
| 3.4.1 | 3.4. Улс, аймгийн аварга малчдыг тодорхойлох, шалгаруулахад орон | Аварга малчдын сүүлийн 3 жилд малжуулсан малчин, мал бүхий өрхийн А дансны бүртгэлээр баталгаажуулах | 2021-2024 | - | Малжуулсан өрхийн тоо | - | 150-аас дээш | СЗДТГ, ХХ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.4.2 | нутгийн орлого багатай өрхүүдийг малжуулах, ядуурлыг бууруулахад оруулсан хувь нэмрийг үнэлж, дүгнэсэн бодит нотолгоо олгох зохицуулалтыг бий болгох; | Орон нутагт ядуурлыг бууруулахад аварга малчдын оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээ авах | 2021-2024 | - | Арга хэмжээний тоо | - | 42 | АЗДТГ, ХХААГ, СЗДТГ, ХХ |
| *Зорилт 4: Малчдын хамтын хоршил, эко санаачилга, байгальд ээлтэй, хариуцлагатай мал аж ахуйг тогтвортой эрхлэхэд чиглэгдсэн арга хэмжээ авах.* | | | | | | | | |
| 4.1.1 | 4.1. Бэлчээрийг зохистой ашиглах, ашиглалтыг сайжруулах, хамгаалах менежментийг үр дүнтэй хэрэгжүүлэх; | Бэлчээр ашиглалтын журам батлан хэрэгжүүлэх | 2021-2024 | - | Журамтай сумын тоо | 3 | 14 | АЗДТГ, ХХААГ, СЗДТГ, ТББ |
| 4.1.2 | | Бэлчээрийн менежментийн төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх | 2021-2024 | - | Бэлчээрийн менежментийн төлөвлөгөөтэй сумын тоо | - | 14 | АЗДТГ, ХХААГ, СЗДТГ, ТББ |
| 4.1.3 | | Ус, бэлчээр ашиглалтын холбоо, бүлэг байгуулах | 2021-2024 | ОНТ 3,5 | Усны бүлэг, БАХ-той сумын тоо | Усны бүлэг-1, БАХ-тай -4 | 14 | АЗДТГ, ХХААГ, СЗДТГ, ТББ |
| 4.2.1 | 4.2. Малын тоог бэлчээрийн даацад тохируулан өсгөх | Аймгийн хэмжээнд бэлчээрийн даацын багтаамж, ашиглалт, хэтрэлтийн төлөв байдлыг судлах | 2020-2024 | - | Судалгааны ажлын тоо | 1 | 4 | АЗДТГ, ХХААГ, БОАЖГ, ГХБХБГ, УЦУОШТ, СЗДТГ |
| 4.2.2 | | Бэлчээрийн даацаас хэтэрсэн малыг зах зээлд нийлүүлэх | 2020-2024 | - | Тухайн жилд зах зээлд нийлүүлсэн малын тоо /мян.тол/ | 223.0 | 230.0 | АЗДТГ, ХХААГ, СЗДТГ, ХХ |
| 4.3.1 | 4.3. Бэлчээр дэх худаг, уст цэгийн тоог нэмэгдүүлэх | Бэлчээр дэх худаг, уст цэгийн ашиглалтын судалгаа гаргах, | 2020-2024 | | Ашиглалтын хувь | 84 | 90 | АЗДТГ, ХХААГ, СЗДТГ, |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ашиглалтыг сайжруулах арга хэмжээ авах | | | | | | ХХ, малчид |
| 4.3.2 | | Инженерийн хийцтэй худаг шинээр болон сэргээн засварлах | 2020-2024 | УТ, ОНТ, ХХ, Малчид | Шинээр болон сэргээн засварласан худгийн тоо | 48 | 70 | АЗДТГ, ХХААГ, СЗДТГ, ХХ, малчид |
| 4.3.3 | | Гар худаг шинээр болон сэргээн засварлах | 2020-2024 | УТ, ОНТ, ХХ, Малчид | Шинээр болон сэргээн засварласан худгийн тоо | 50 | 200 | АЗДТГ, ХХААГ, СЗДТГ, ХХ, малчид |
| 4.4.1 | 4.4. Бэлчээрт хор хөнөөл учруулж буй мэрэгч амьтан, шавжтай тэмцэх арга хэмжээ авах | Бэлчээрт хөнөөл учруулж буй мэрэгч амьтны судалгаа хийх | 2020-2024 | УТ, ОНТ | Тухайн жилийн судалгааны ажлын гүйцэтгэлийн хувь | 100 | 100 | ХХААГ, СЗДТГ |
| 4.4.2 | | Судалгааны үр дүнд тулгуурлан мэрэгч амьтан, шавьжтай тэмцэх ажлыг орон нутгийн малчид, хоршоо, нөхөрлөлтэй хамтран зохион байгуулах | 2020-2024 | УТ, ОНТ | Тухайн жилд зохион байгуулсан сумын тоо | 5 | 2 | ХХААГ, СЗДТГ |
| Нийт | | | | 309,1 | | | | |

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:

ХОХБТХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН /Н.БЯМБАЦЭЦЭГ/

ХЯНАСАН:

ХОХБТХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН /А.АМГАЛАНЗАЯА/

**“АТАР -4 ТАРИАЛАНГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН АЯН”-ЫГ ОРОН НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**
**/2020-2025/**

2020 оны 08 дугаар сарын 04-ний өдөр | Сайншанд

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Төсөв /сая.төг/ | Хэрэгжих хугацаа | Хэрэгжүүлэх байгууллага | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Үндсэн | Хамтран |
| Зорилт 1: Төмс хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлжлэн өвөл, хаврын улиралд хүн амыг шинэ ургацын хүнсний ногоогоор хангах; | | | | | | | | |
| 1.1 | Төмс, хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэх | Тариалсан талбай хэмжээ /га/ | Төмс -11 га, хүнсний ногоо 41 га талбайд тариалж, 88 тн төмс, 250 тн хүнсний ногоо хураан авсан. | Төмс - 15 га, хүнсний ногоо 45 га талбайд тариалах | 5,0 | 2020-2025 | ХХААГ | Аймаг, сумдын ЗДТГ, ААН, байгууллага, ОУБ, ХХ |
| 1.2 | Өвөл, зуны хүлэмжийн аж ахуй байгуулахад урт хугацаатай зээлийн эх үүсвэр бий болгох, гадаад, дотоодын төсөл, хөтөлбөр, олон улсын байгууллагын санхүүжилтээр цогцолбор аж ахуй байгуулах | Хүлэмжийн аж ахуйн талбайн хэмжээ | зуны 9300 $м^2$, өвлийн 600 $м^2$ талбайд тариалалт хийдэг. | Зуны 12000 $м^2$, өвлийн 700 $м^2$, нарлаг хүлэмж-1500 $м^2$ | 20,0 | 2020-2025 | ХХААГ | Аймаг, сумдын ЗДТГ, ААН, байгууллага, ОУБ, ХХ |
| 1.3 | Орон нутгийн тариаланчдын үйл ажиллагааг сурталчлах, борлуулалтыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах | Тухайн жилд зохион байгуулсан арга хэмжээний тоо | Жил бүр аймаг, сумын үзэсгэлэн худалдаа зохион байгуулж хэвшсэн. | 2-оос дээш | 3,0 | 2020-2025 | ХХААГ | Аймаг, сумдын ЗДТГ, ААН, байгууллага, ОУБ, ХХ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.4 | Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнийг ялгах, савлах, хатаах тоног төхөөрөмж, хадгалалтын шинэ арга технологийг нэвтрүүлэхэд дэмлэг үзүүлэх | Хамрагдсан иргэдийн тоо | - | 30-аас доошгүй | 1,0 | 2020-2025 | ХХААГ | Аймаг, сумдын ЗДТГ, ААН, байгууллага, ОУБ, ХХ |
| 1.5 | Төмс, хүнсний ногооны үрийн нөөц бүрдүүлэх, шинэчлэл хийхэд дэмжлэг үзүүлэх | Үрийн хангамжийн хувь | 13 | 30 | 2,0 | 2020-2025 | ХХААГ | Аймаг, сумдын ЗДТГ, ААН, байгууллага, ОУБ, ХХ |
| 1.6 | Орон нутгийн онцлогт тохирох таримлын тариалалтыг нэмэгдүүлэх, шинэ төрлийн жимс, жимсгэнэ тариалахад сургаж, дадлагжуулах | Хамрагдсан өрхийн тоо | 10 | 15-аас доошгүй | 3,5 | 2020-2025 | ХХААГ | Аймаг, сумдын ЗДТГ, ААН, байгууллага, ОУБ, ХХ |
| 1.7 | Стандартын шаардлагад нийцсэн зоорийг нэмэгдүүлэх | Зоорийн тоо | 17 | 20 | - | 2020-2025 | ХХААГ | Аймгийн ЗДТГ, ХХҮГ Сумдын ЗДТГ, ХХ |
| Зорилт 2: Хөрс хамгаалах технологид нийцсэн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх замаар хүнсний ногооны үйлдвэрлэлийг эрчимжүүлж, усалгаатай тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх; | | | | | | | | |
| 2.1 | Бүс нутгийн онцлогт тохирсон дуслын усалгааны дэвшилттэй технологийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх. | Усалгааны систем нэвтрүүлсэн талбайн хэмжээ хэмжээ /га/ | 20 га | 28 га | 57,3 | 2020-2025 | ХХААГ | Аймаг, сумдын ЗДТГ, ААН, байгууллага, ОУБ, ХХ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2 | Ургамал хамгааллын цогц арга, газар тариалангийн зохистой дадлыг нэвтрүүлэх арга хэмжээ авах | Судалгаа, шинжилгээнд хамрагдсан талбайн хэмжээ /га/ | 44 | 80 | 2,0 | 2020-2025 | ХХААГ | Аймгийн ЗДТГ Сумдын ЗДТГ, ХХ |
| 2.3 | Газар тариалангийн техникийн шинэчлэл, хангамжийг нэмэгдүүлэх | Техник, тоног төхөөрөмжийн хангамжийг хувь | 23 | 40 | - | 2020-2025 | ХХААГ | Аймаг, сумдын ЗДТГ, ААН, байгууллага, ХХ |
| 2.4 | Тариалангийн газрын ашиглалтыг сайжруулах, сэлгэн тариалах газар олгох | Сэлгэн тариалсан талбайн хэмжээ /га/ | 100-102 га | 107 га | - | 2020-2025 | ХХААГ | Аймаг, сумдын ЗДТГ |
| 2.5 | Тариаланчдад ургамал хамгааллын бодис, бордоо зэргийг хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох | Хамрагдсан иргэн, ААН-ийн тоо | - | жилд 10-аас доошгүй | 2,0 | 2020-2025 | ХХААГ | Аймаг, сумдын ЗДТГ, ААН, байгууллага, ХХ |
| Зорилт 3: Хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэжилтэй ажилтан бэлтгэх, давтан сургах, мэдээллээр хангах замаар хүний нөөцийн чадавхыг сайжруулах; | | | | | | | | |
| 3.1 | Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд ногоочин, техникийн ажилтан бэлтгэх сургалтад сургах, мэргэшүүлэх | Бэлтгэгдсэн ногоочин, техникийн ажилтны тоо | 20 | Жилд 15-аас доошгүй | - | 2020-2025 | ХХААГ | Аймаг, сумдын ЗДТГ, МСҮТ, ТББ |
| 3.2 | Газар тариалангийн чиглэлээр хөрш, хамтын ажиллагаатай орнуудад тариаланч, мэргэжилтнүүдийг туршлага судлуулах | Хамрагдсан хүний тоо | - | Жилд 1-ээс дээш | 2,0 | 2021-2025 | ХХААГ | Аймаг, сумдын ЗДТГ, ААН, байгууллага, ХХ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3 | ЕБС-ийн сурагчдын экологийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл амьдралын хэв маягт сургах, харилцан туршлага судлуулах, тэргүүн туршлагыг бүх нийтэд түгээн дэлгэрүүлэх арга хэмжээ авах | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 1 | Жилд 3-аас доошгүй | 3,0 | 2020-2025 | ХХААГ | Аймаг, сумдын ЗДТГ, ААН, ТББ, байгууллага, ХХ |
| 3.4 | Хүлэмжийн аж ахуй эрхлэгчдэд гидропоник орчинд тариалалт хийх арга, технологи нэвтрүүлэх чиглэлээр туршлага судлуулах | Хамрагдсан аж ахуй эрхлэгчдийн тоо | - | 5-аас доошгүй | 2,0 | 2021-2025 | АЗДТГ, ХХААГ | Сумдын ЗДТГ, ААН, ТББ, байгууллага, ХХ |
| **Нийт** | | | | | **102,8** | | | |

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:

ХОХБТХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН /Н.БЯМБАЦЭЦЭГ/

ХЯНАСАН:

ХОХБТХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН /А.АМГАЛАНЗАЯА/